



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР**

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn


2018.02.22 № 95
таний —ны № —т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ^Т
АХҮЙН ГАЗРЫН ДАРГА Б.МОНХЖАРГАЛ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд албан шаардлагыг хүргүүлж байна.

1
Хавсралт хуудас

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА



D:\office\Alban bichig\A5\Хүргүүлэх тоот.docx



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01145 ДУА-2018/1/СТА-ПЦ/З Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хөрөнгөөр 5,205,950.00 /таван сая хоёр зуун таван мянга есөн зуун тавин/ төгрөгийн урсгал засвар хийсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлтийг байхаар төлөвлөж, зарцуулах/, Монгол Улсын Их Хурлын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 47 дугаар товоолын 4-т /эмнэлэг, цэцэрлэг, сургуульд зайлшгүй урсгал засвар хийхээс бусад тохиолдолд төсвийн байгууллагын албан контор, ажлын байранд урсгал засвар хийхгүй байх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн толбор, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тоогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тоогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тоогтоомж зорчсон алдаа, зөрчлийг маслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлоотэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ Нь:

- Батлагдсан төсвийн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулах, төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллах;

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын төсвийн шууд захирагч Б.Мөнхжаргал, нягтлан бодогч Б.Энхдөл нарт хариуцуулав.

АУДИТОР	Ж.УГТАХБАЯР	ДАРГА	Б.МОНХЖАРГАЛ
ӨГСӨН:	АЛБАН ШААРДЛАГЫГ	ЗӨВШӨӨРСӨН:	Б.ЭНХДӨЛ
НЯГТЛАН БОДОГЧ			
Номер: 3KA0024 Номер: 3114 4815100553			

¹ Акт, албан шаардлагын биеэлээт ханаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биеэлүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.